



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/Б/44

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 10 дугаар зүйлийн 10.1.5, 16 зүйлийн 16.2, 16.2.2. аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2017 оны 53 дугаар тогтоолын 5 дугаар бүлгийн 5.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй "Оол-Эм" эмийн сангийн тусгай зөвшөөрлийн хугацааг 5 жилээр Биндэр суманд үйл ажиллагаа явуулж буй "Өсөн өрнөх" эмийн сангийн тусгай зөвшөөрлийг 3 жилээр, "Монос Хэнтий ХХК" эм ханган нийлүүлэх байгууллагад мансууруулах, сэтгэц нөлөөт эмийг худалдаалах тусгай зөвшөөрлийг 3 жилээр тус тус сунгасугай.

2. Дээрх байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Гэрэлмаа/-д үүрэг болгосугай

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА